



# **МОНГОЛ УЛСЫН ОЛОН УЛСЫН ХАМТЫН НИЙГЭМЛЭГ ДЭХ ОРОЛЦОО**

**Нийгэм судлал 10-р анги**

**Багш Д.Уранцэцэг**

**III улирал.**

**Email: D.Urantsetseg 55@gmail.com**

# ХИЧЭЭЛИЙН ЗОРИЛГО

- Монгол улсын олон улсын хамтын нийгэмлэг дэх оролцоо, түүний хэлбэр, чиглэлийг тодорхойлох үзүүлэлтүүдийг томъёолох
- Манай улсын олон улсын хамтын нийгэмлэг дэх оролцоотой холбогдох эх сурвалж, баримт бичгүүдээс сонгосон эхийг шинжлэх дасгал ажиллах.

# ТУЛГУУР ОЙЛГОЛТ

- Нэгдсэн Үндэсний Байгууллага (НҮБ) нь олон улсын хууль, эдийн засгийн хөгжил, аюулгүй байдал, нийгмийн асуудлууд болон хүний эрхийн талаар хамтран ажиллах зорилго бүхий олон улсын байгууллага юм.
- Олон Улсын Валютын Сан(ОУВС) нь мөнгө болон валютын зах зээлийн тогтвортой байдлыг хангах зорилготой олон улсын хамтарсан мэргэжлийн байгууллага юм. 1944 оны 7 сард АНУ-ын Нью-Хэмпшир муж улсын Брэттон Вүдст нээгдсэн.

- Дэлхийн банк (ДБ) нь өөрийн гишүүн хөгжиж буй орнуудад ядуурлыг бууруулах зорилгоор зээл тусламж олгодог банк юм. 1944 онд байгуулагдсан. Одоо 188 улс оронд үйл ажиллагаа явуулдаг.
- Азийн хөгжлийн банк (АХБ) нь НҮБ-ын Ази, Номхон далайн бүс нутгийн Эдийн засаг, нийгмийн комиссын гишүүн байгууллага юм. 1966 онд байгуулагдсан. Дэлхийн 67 оронд үйл ажиллагаа идэвхтэй явуулдаг.
- АСЕМ нь Ази, Европын орнуудын эрх тэгш харилцаанд суурилсан улс төр, эдийн засаг, нийгэм соёлын нийтлэг тулгамдсан асуудлыг хэлэлцдэг Засгийн газар хоорондын албан бус яриа хэлэлцээний хамтын ажиллагааны байгууллага юм.


# НЭГДСЭН ҮНДЭСНИЙ БАЙГУУЛЛАГА

НҮБ нь 1945.10.24-нд АНУ-ын Калифорни муж улсын Сан-Франциско хотод 51 гишүүн оронтойгоор байгуулагдсан юм. Өнөөдөр дэлхийн 193 улс гүрэн энэхүү байгууллагад элсжээ.



Нью-Йорк дахь НҮБ-ын төв байр

# НҮБ нь 5 үндсэн байгууллагаас бүрдэнэ




# Монгол улсын олон улсын хамтын нийгэмлэг дэх оролцоо

Монгол Улс НҮБ-д 1961 онд 101 дэх гишүүнээр элссэн. Монгол улс олон улсын хамтын нийгэмлэгийн бүрэн эрхт гишүүн болсноор НҮБ-ийн системийн байгууллагууд, олон улсын гэрээ, хэлэлцээрүүд олон талт хамтын ажиллагаанд оролцох өргөн боломжийн нээсэн.

Монгол Улсын санаачилгаар НҮБ нь 1970-аад оныг "Бичигтэн болох 10 жил" хэмээн зарлаж байв. Монгол Улс нь НҮБ-ын цөмийн зэвсгийн эсрэг тэмцлийг тууштай дэмжиж, Цөмийн зэвсэггүй бүс нутаг хэмээн зарлажээ. Манай улс өдгөө дэлхийн 173 улстай албан ёсны харилцаа тогтоож, Олон Улсын болон бүс нутгийн засгийн газар хоорондын 70 гаруй байгууллагад элсээд байна.

# Хамгийн өргөн хүрээнд хамтран ажилладаг олон улсын байгууллагууд





# Монгол улсын Олон Улсын хамтын нийгэмлэг дэх оролцооны зарчим

Үндэсний  
эрх ашигт  
нийцсэн  
байх


Олон  
тулгуурт  
байх

Прагматик  
байх

Тэнцвэртэй  
байх

МОНГОЛ ДАХЬ АСЕМ-ИЙН ДЭЭД ХЭМЖЭЭНИЙ УУЛЗАЛТ  
2016 онд Улаанбаатар хотноо зохион байгуулагдсан юм.





АСЕМ нь 1996 онд 26 гишүүнтэй үйл ажиллагаагаа эхэлж байсан Ази-Европын яриа хэлэлцээний чуулган эдүгээ 51 орон, 2 олон улсын байгууллагыг эгнээндээ нэгтгэсэн. АСЕМ-ийн дээд хэмжээний уулзалт нь эрх тэгш түншлэл, харилцан итгэлцэлд суурилсан Ази Европын стратегийн яриа хэлэлцээ, үр ашигтай хамтын ажиллагааг эрчимжүүлэх зорилготой уулзалт юм. 2006 онд Финляндад болсон АСЕМ-ийн 6-р уулзалтын үеэр Монгол улс анх нэгдэн орсон юм. Уулзалтад нэгдэн орсноор улс төрийн гадаад бодлогын зорилго болох улсын аюулгүй байдал, хөгжил дэвшлийг хангах таатай гадаад орчин бүрдүүлэх, дипломат болон консулын харилцаа хөгжүүлэх, дэлхий нийтийн тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд хувь нэмрээ оруулах боломжийг нэмэгдүүлж буй явдал юм.

# БИЕ ДААЖ ХИЙХ ДААЛГАВАР-1



- 1.НҮБ Олон Улсын харилцаанд хэрхэн оролцдог ямар нөлөөтэй байгууллага вэ?
- 2.Манай улс НҮБ-д элссэн нь ямар ач холбогдолтой болсон бэ?
- 3.Монгол улс ба НҮБ-ын хамтын ажиллагааны гол хэлбэр , үндсэн чиглэлүүдийг тайлбарлан бичнэ үү?

# БИЕ ДААЖ ХИЙХ ДААЛГАВАР-2



## Asia-Europe Meeting 11

20 YEARS OF ASEM | ULAANBAATAR 2016

1. Олон улсын хамтын нийгэмлэгийн үйл ажиллагаанд манай улс хэрхэн оролцож байна вэ?
2. АСЕМ-ийг зохион байгуулсан нь Монгол улсын Олон улсын хамтын нийгэмлэг дэх оролцоонд хэрхэн нөлөөлсөн бэ?

# ГЭРИЙН ДААЛГАВАР

1. Бие дааж хийх даалгавар 1,2,-г дэвтэртээ хийгээрэй.
2. Сурах бичгийн 132-135 хуудсыг сайн уншиж судлаарай.